

ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХЖ

2019 оны 09 дүгээр сарын 16

**ӨДТ ЦЕХИЙН МАШИН ЗААЛНЫ ДЭЭВРИЙН БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ
ШУГАМ ХЭСЭГЧЛЭН СОЛИХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт /
гэрээний нэр:

**ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус
зайлуулах шугам хэсэгчлэн солих ажил**

Тендер шалгаруулалт /
гэрээний дугаар:

БИЗ-06/2019

ДЦС-3

Улаанбаатар хот
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус зайлуулах шугам хэсэгчлэн солих ажил”**-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж, 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 16.00 цагаас өмнө цахим системээр ирүүлнэ. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2019 оны 09-р сарын 23-ны өдрийн 16.05 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.
Веб хуудас: www.tes3.energy.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тендерийн үнэ
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж

- залруулах** дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	
ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөл болон холбогдох баримт бичгийг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 1 <i>жил (2018 он)-ийн</i> жилийн санхүүгийн тайлан ирүүлэх. (Аудитаар баталгаажуулсан байх) 2. Сүүлийн 1 <i>жил(2018 он)-ийн</i> туршлагын мэдээлэл (Сүүлийн нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй ижил төстэй ажил хийсэн гэрээ, гэрээ дүгнэсэн актны хуулбар) 3. Сүүлийн 1 <i>жил(2018 он)-ийн</i> борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. 4. Ажил гүйцэтгэх төсвийг мэргэшсэн төсөвчнөөр баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. 5. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар 6. Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл болон гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан хуулбар (Ажил үйлчилгээний төрлийн 2.1.1, 2.1.2, 2.2.1, 2.2.2 дахь нөхцөл, шаардлагуудыг хангасан байна). 7. Аж ахуйн нэгжийн товч танилцуулга 8. Татварын албаны цахим тодорхойлолт (Өргүй байх) 9. Харьяалагдах нийгмийн даатгалын хэлтсийн тодорхойлолт. (Өргүй байх) 10. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт 12. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын тодорхойлолт 13. Аж ахуйн нэгжийн гэрчилгээн дээр бүртгэлтэй банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй гэсэн тодорхойлолт ирүүлэх 14. Ажил гүйцэтгэх хуваарь ирүүлэх 15. Нийгмийн даатгалын дэвтэр, шимтгэл төлөлтийн хуудас, НД8 маягтын хамт ирүүлэх сүүлийн 6 сараар. 16. Гэрээг хариуцан ажиллах ерөнхий инженер-1, хөдөлмөр хамгааллын ажилтан-1 томилох. Ерөнхий инженер нь тухайн байгууллагатаа 6 сараас дээш хугацаанд ажилласан байх. Мэргэжлийн үнэмлэх, диплом хавсаргах 17. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажил гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. <i>Автомашин</i> 2. <i>Автокран</i> 3. <i>Автовышка</i> 4. <i>Гагнуурын аппарат</i> 5. <i>Нивеллер</i> гэх мэт 18. Хуудас бүрийг дугаарлах: Цахим тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд хуудас бүрийг дугаарлаж гарын үсэг зурж баталгаажуулсан байна. 19. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх бол төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ

<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг, 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот</i></p> <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Нэр дугаарыг гаргацтай тэмдэглэнэ. <i>ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус зайлуулах шугам хэсэгчлэн солих ажил. Дугаар: БИЗ-06/2019</i></p> <p>Огноо: <i>2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>16 цаг 00 минут</i></p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хан-Уул дүүрэг, 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Захиргааны байрны 2-р давхар, Зөвлөлгөөний танхим</i></p> <p>Огноо: <i>2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр</i> Цаг: <i>16 цаг 05 минут</i></p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Батлагдсан барилгын засварын ажлын эзэлхүүний дагуу хийж гүйцэтгэнэ. Ажлын эзэлхүүн, ажлын зургийг тендерийн баримт бичигт хавсаргав.

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ХХ-129-2015 Хувилбар 1
---	--	-------------------------------

БАТЛАВ.
"ДЦС-3" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ЧИНБАТ



ӨДТ ЦЕХИЙН МАШИН ЗААЛНЫ ДЭЭВРИЙН БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ ХЭСЭГЧЛЭН СОЛИХ АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН

2019.08.16

Д/д	Гүйцэтгэх ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Борооны усны шугамын бөглөөг гаргаж, усаар шахаж гаргах	км	0,62
2	Дотуур зайлуулагчтай хайрган хучилттай дээврийн борооны ус авах торыг хуулж, юлүүр хоолойн битүүрсэн хогийг цэвэрлэн буцааж угсрах	ш	50
3	Гагнаж залгасан 159мм, 108мм голчтой яндан хоолойг буулгах	м	108
4	Дээврийн борооны ус урсах хоолойн хэсгийн хөндийрсөн хар цаас хуулах	м2	168
5	Борооны усны шугамын цоорсон 108мм, 159мм голчтой чиг өөрчлөгчийг буулгах	ш	14
6	Борооны усны шугамын 108мм, 159мм голчтой чиг өөрчлөгч солих	ш	14
7	8м-ээс дээш өндөр барилгын 108мм, 159мм голчтой борооны усны хоолойг солих	м	50
8	Хуучин 108мм, 159мм голчтой яндан хоолойн нимгэрсэн хэсгийг дээш нь харуулж эргүүлж угсрах	м	58
9	Борооны ус зайлуулах яндан хоолой будах	м2	80
10	Борооны ус зайлуулах хоолойн дээвэрт нэвт хэсгийн цагираг чигжих	ш	50
11	Дээврийн ус урсах хоолойн цементэн тэгшилгээг засварлах	м2	108
12	Дээврийн бетон ба зуурмаг тэгшилгээн дээр ус тусгаарлах үеийн хөрсжүүлэлт хийх	м2	168
13	Дээврийн борооны ус урсах хоолойн хэсэгт 2 үе хар цаас наах	м2	168
14	18м хүртэл өндөр дүүжин шат угсрах ба задлах	м2	70
15	Барилгы хог ялгаж овоолох ба автомашинд эксковатораар ачих	м3	15

Хянасан: Ерөнхий инженер  Л.Нямхүү
ТХХ-ийн дарга  Д.Төмөрбаатар

Ажлын эзэлхүүн гаргасан:
ӨДТ цехийн дарга  Э.Нямдаваа
БЗХ инженер  П.Баатарцогт

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЧИНБАТ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], “ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус зайлуулах иугам хэсэгчлэн солих ажил (БИЗ-06/2019)”-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 2. **Төслийн менежерийн шийдвэр**
 3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 4. **Аюулгүй байдал**
 5. **Зааварчилгаа**
 6. **Маргааныг шийдвэрлэх**
 7. **Ажлын хөтөлбөр**
 8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 9. **Зөрчил, гологдол арилгах**
 10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
- 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
 - 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
 - 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
 - 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ²

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус зайлуулах шугам хэсэгчлэн солих ажил, БИЗ-06/2019
ГЕН 2.1	Ажил нь Өндөр даралтын турбин цехийн барилгын дээврийн борооны ус зайлуулах шугам хэсэгчлэн солих ажлаас бүрдэнэ. Ажлын талбай нь “ДЦС-3” ТӨХК-ийн Өндөр даралтын турбин цехэд байрших ба барилгын засварын ажлын эзэлхүүн, хяналтын төсөвт зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь БЗХ-ын инженер П.Баатарцогт, утас: 70111321
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2019 оны 09-р сар Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны 10-р сар³
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,3 хувь байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 30 хувиас хэтрэхгүй байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [огноо]-ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг магадлашгүй ажлын нормоор тооцно.
ГЕН 20.1	Урьдчилгаа төлбөрийн дүн нь Гэрээт ажлын 100%-ийн гүйцэтгэлээр 95%-ийн төлбөр, баталгаат хугацаа дууссаны дараа 5%-ийн үлдэгдэл төлбөрийг ажил хүлээн авсан комиссын акт, техникийн бичиг баримтыг үндэслэн төлнө.

² Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.

Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

³ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

Барилга угсралт, засварын ажил гүйцэтгэх гэрээ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар № _____

Улаанбаатар хот

Нэг талаас **[захиалагчийн нэр]** төлөөлж, (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэр]** төлөөлж (цаашид “Гүйцэтгэгч” гэх) хамтад (талууд гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, **[захиалагчийн нэр]** барилгын ажил, үйлчилгээний тендерийн үнэлгээний хорооны хурлын ___ тоот шийдвэр, Үнэлгээний хорооны ___ тоот зөвлөмжийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламжийн засварын ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх хариуцлагыг тогтооход оршино.

1.2. Энэхүү гэрээгээр барилга угсралт, засварын ажлын үнэ, чанар, гүйцэтгэх хугацааг эцэслэн тохирох үндэслэл болно.

1.3. Тус гэрээ нь **“ӨДТ цехийн машин заалны дээврийн борооны ус зайлуулах шугам хэсэгчлэн солих ажил”**-ыг **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр (НӨАТ болон бусад холбогдох зардлууд багтсан) ___ оны ___ сарын ___-ны өдрөөс ___ оны ___ сарын ___-ны өдрийг хүртэл хуанлийн ___ хоногийн хугацаанд хүчинтэй.

1.4. Гэрээг ажлын эцсийн гүйцэтгэлээр хоёр тал дүгнэнэ.

1.5. Гэрээнд оролцогч талууд нь гэрээнд тусгагдсан эрх, үүрэг, хариуцлагаа бүрэн биелүүлж, бүх талын боломжоор харилцан туслалцаж хамтран ажиллана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Барилга угсралт, засварын ажил эхлэх зөвшөөрөл, бусад бичиг баримтыг ажил эхлэхээс 3 хоногийн өмнө гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

2.2. Барилга угсралт, засварын ажлын явц, чанарт холбогдох мэргэжилтэн буюу зохиогчоор хяналт тавиулж, далд ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна.

2.3. Зураг төслийн норм ба барилгын ажлын технологи зөрчсөн, чанарын гологдол гаргасан, санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан, материал, тээвэр, механизмын үнийн зөрүүг буруу тооцсон зэрэг тохиолдолд захиалагч нь эрх бүхий байгууллагаар экспертиз хийлгэж торгууль ногдуулах, гарсан хохирол, зардлыг гүйцэтгэгчээр төлүүлэх, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.

2.4. Барилга угсралт, засварын ажлын явцад гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь хэмжин шалгалт хийж баталгаажуулан санхүүжилтийг хийнэ.

2.5. Захиалагч техник хяналтыг хийх хугацаандаа гүйцэтгэгчээс зураг төсөв зөрчиж буруу, дутуу, чанаргүй хийсэн ажлыг засахыг шаардах ба шаардлагыг биелүүлэх хүртэл санхүүжилтийг зогсоох эрх эдэлнэ.

2.6. Гэрээгээр зөвшөөрөлцсөн ажлын тоо хэмжээнээс хэтрүүлэн гүйцэтгэсэн ажлын зардлыг санхүүжүүлэхгүй.

2.7. Хэрэв зайлшгүй хийх шаардлагатай ажил гарвал комисс бүрдүүлэн газар дээр нь шалгаж, гэрээний нэмэлт ажлын акт үйлдэж, хөрөнгийг хяналтын төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлнэ.

2.8. Ажлыг далдлах талаар гүйцэтгэгчээс өгсөн мэдэгдлийг авснаас хойш 5 хоногийн дотор захиалагч үзээгүй бол гүйцэтгэгч ажлаа үргэлжлүүлэх бөгөөд далдлагдсан ажлыг дахин үзэх шаардлага гарсан тохиолдолд холбогдох зардлыг захиалагч хариуцна.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1.Гэрээнд заагдсан барилга угсралт, засварын ажлыг зураг төсөл, БНБД, стандартын дагуу чанартай хийж, энэхүү гэрээнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан ашиглалтанд оруулан захиалагчид хүлээлгэн өгнө.
- 3.2.Буруу буюу дутуу, БНБД зөрчиж хийсэн ажлыг тухай бүр өөрийн хөрөнгөөр засч гүйцээх, ажлын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгахын хамт угсарсан тоног төхөөрөмж, шугам сүлжээндээ туршилт тохируулга хийж найдвартай ажиллагааг хангана.
- 3.3.Барилга байгууламжийн засварын ажлыг байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
- 3.4.Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад гүйцэтгэгч талын буруутай үйл ажиллагааны улмаас зөрчил, доголдол илэрвэл түүнийг өөрийн хөрөнгөөр засна.
- 3.5.Гүйцэтгэгч байгууллага нь барилгын ажлын гүйцэтгэлийн зургийг үнэн зөв гаргаж, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршин тохируулсан актыг захиалагчид бүрэн гүйцэд хүлээлгэн өгнө.
- 3.6.Туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг ерөнхий гүйцэтгэгч захиалагчийн өмнө бүрэн хариуцна.
- 3.7.Барилга угсралт, засварын ажлын явцад ажиллаж буй ажилтнуудад өдөр тутам хийх ажлын онцлог, гарч болох эрсдлийн талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, ажлын байрны аюулгүй байдлыг ханган хүн нэг бүрт хамгаалах хэрэгслэлийг иж бүрэн хэрэглүүлж, зориулалтын шат тавцан, хашлага ашиглан ажилтнуудын мэргэжлийн сургалт, эрүүл мэнд, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1.Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн тал нь гэрээний үнийн дүнгийн 0,3 хувиас хэтрэхгүй хэмжээгээр буруутай талдаа алданги ногдуулна. (Алдангийн хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.)
- 4.2.Баталгаат 1 жилийн хугацаанд илэрсэн эвдрэл гэмтлийн актыг захиалагч, гүйцэтгэгч хамтран тогтоож буруутай талын хөрөнгөөр засуулна.
- 4.3.Алданги, хохирол төлсөн нь гүйцэтгээгүй үүргийг нөхөн биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 4.4.Талууд гэрээний биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Тав. Мөнгөн төлбөр, түүнийг гүйцэтгэх арга зам

- 5.1.Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээт ажил хүлээн авсан комиссын акт, техникийн бусад бичиг баримтыг үндэслэн нэхэмжлэлээр ажлын 14 хоногт багтаан төлж барагдуулна.
- 5.2.Гүйцэтгэсэн ажилд баталгаат хугацааны барьцаа 5%-иар тооцож, 1 жилийн хугацаатай авч үлдэнэ.

Зургаа. Бусад зүйл

- 6.1.Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, гүйцэтгэгч тал 1 хувийг, захиалагч тал 3 хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй байна.
- 6.2.Талуудын санал зөрөөтэй асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 6.3.Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нь үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.4.Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 6.5.Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]